

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Гомбо	Дугаар	L017
Оршин суугаа аймаг	Улаанбаатар хот	Оршин суугаа сум	
Төрсөн газар	Өвөрхангайн Бүрд сум	Төрсөн он	1913
Ажил мэргэжил	Хамба лам		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Баруун хүрээ буюу Шанхын хийд	Сүм хийдийн дугаар	ӨХХХ 016
Одоогийн сүм хийд	Ламрим хийд	Сүм хийдийн дугаар	УВ 04
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 11-р сарын 10	Ярилцлага авсан хүн	Ч. Хулан



Өвөрхангай аймгийн Хархорин сумын Баруун хүрээ буюу Шанхийн хийд

Энэ олон сүм хийдийг цэгцлэх хэрэгтэй. Олон янзын нэртэй хурал сүмийн газар шашны асуудлаар мөн чанартай ч биш зарим нэг тал нь, тухайлбал сүсэгтний холбоо гэж байгуулагдлаа шүү дээ тэр холбооны бодлого бол ямар хурлаа хийх, ямар үйл ажилгаа явуулах тэрийг хориглох явдал байхгүй гэдгээр ийм байдалд хүргэж байгаа юм. Олз хайж чанаргүй зүйл хийж ард түмний хөрөнгөөр тоглож байна. Анх шашин сэргэхэд

- 1.Хүүчин уламжлалт гол хийдийг сэргээх,
- 2.Хүн бүр чөлөөтэй боллоо гэж мэдэх мэдэхгүй олон юм гарч ирлээ.

Гэгээний 7 орон гэж байсан. Өндөр гэгээн гараараа байгуулсан долоон гол сүм хийд байсан юм. Хамгийн анхан нь:

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

1. Баруун хүрээ-Ривуу гэж ганданшадувлин. Хангайн салбар уул Шанхын уулын өвөрт Сайхан булгийн дэнжид, Шарын голын хөвөөнд анх 7 ламтай Ганданшадувлин хийдийн анхны хурлыг хүржээ.Одоогийн Өвөрхангай аймгийн Хархориноос урагш юм.
2. Хэнтий аймагт Хэнтий уулын өвөрт, Хэрлэн голын хөвөөнд Хэрлэнгийн Зүүн хүрээ гэдгийг байгуулсан. Одоо буурин дээр нь уурхай байгуулагдсан байгаа.
3. Дөрвөн уулын хооронд Дашчойлин нэртэй Нийслэл хүрээ гэдгийг байгуулсан дөрвөн уулын хооронд Гэгээний байгуулсан хоёр хүрээ байсан.
4. Мөн Дөрвөн уулын хооронд Дамбадаржаа гэж байгуулсан одоо тэр хойно хүрж байна.
5. Хангай уулын оргилд Төвхөн хийд гэдгийг байгуулсан. Өндөр гэгээн өөрөө бясалгал даяанаа хийдэг байсан өөрөө байгуулсан хийд
6. Одоогийн Сэлэнгийн нутагт Бүрэнхаан уулын өвөрт Амарбаясгалант хийдийг байгуулсан. Гурдаваа ринбүүчи дахин сэргээж бүрэн бүтэн болгосон. Тэнд Өндөр гэгээний шарилыг ч хадгалсан.
7. Хөгнө хан уулын Тарнийн голын эрэгт Жамсран сахиусны орон Пунцогчойнбэллин Тарнийн хийд гэдэг сүүлд Эрдэнэ хамбын хийд.Эрдэнэ хамба Гэгээний жавтүй хамба нь байсан. Өглөө нүүр гараа угаахад нь жавтүй уншиж нүүр гарыг нь угаалгадаг байсан. Хөгнө хан уул гэдэг чинь Их хаан уул юм. Учир нь Өөлд, Халхын дайн гарах үед Галдан Бошготын цэргүүд лам нарыг нь хөгнөж хороосон юм гэнэлээ. Тэгээд Хөгнө хан уул гэж нэрлэсэн.

Өндөр гэгээний долоон орон гэж энэ. Өндөр гэгээний өөрийн таалал бол Монголд 360-аас дээш сүм хийд байгуулахгүй гэж байсан ч 2,3-р богдын үеэс их дэлгэрсэн. Тэр нь чанартай байлгахыг эрхэмлэж байсан. Сэцэн хаан аймагт Бэрэйвэн хийд гэж их том хийд байсан. Эрдэнэ зуу хийд Монголын анхны хийд. Манай баруун хүрээг Өвгөн хүрээ гэж нэрлэдэг байсан. Түшээт ханы нутагт Эрдэнэ зуу, Баруун хүрээ мөн Түшээт ханы засаг хошуу, Булганы нутагт Ханд чин вангийн хүрээ гэж их том хүрээ байсан. Түшээт ханы нэг том хошуу Говь түшээ гүний хошуунд их том хийдүүд байсан. Одоогийн Дундговь аймгийн нутагт Зүүн чойр, Баруун чойр, Зава ламын хийд гээд их хийдүүд байсан. Говийн догшин ноён хутагтын хүрээ Байшинтын хүрээ гэж том хүрээ байсан. Заяын дээд хүрээ доод хүрээ гэж байсан.Чимэддэлэг бэйсийн хүрээ урд бэйсийн хүрээ, хойд бэйсийн хүрээ Одоогийн Архангайн Өлзийт суманд Оромбо далай ламын хүрээ гэж их том төвд дэгтэй хүрээ байсан. Архангай аймаг Түшээт хааны гол нутаг. Хувьсгалын үед 700 гаруй сүм хийдийн 300 гаруй нь Архангайнх гэж байсан бусад нь өөр газрынх. Баянхонгорт Ламын гэгээний хийд гэж их том газар байсан. Засагт ханы нутаг. Мөн Ховдод Шар сүм гэж байсан. Яруугийн хүрээ Завханд байсан юм.

Өндөр гэгээний их хийдүүд Түшээт хан аймгийн нутагт байсан. Богдын хүрээ анхан гэр бариад, хурлаа хураад нүүж явдаг байсан гэдэг сүүлдээ Сөгнөгөр баян гол гэдэгт гэр бариад хүрж байгаад энэ Дөрвөн уулын дунд суурьшин байгуулагдсан. Манай баруун хүрээ ч мөн адил Гуульт шороот гэдэг газраас нүүж Сайхан булгийн дэнжид ирж төвлөөд тэндээ дөрвөн аймагтай

1. Тойсамлин

Энэхүү нэр дурдсан хүний аман ярилцлагын үгчилсэн тэмдэглэл нь зөвхөн ярилцагчийн хувийн мэдээллээс бүрдсэн болно.
© Монголын Урлагийн Зөвлөлийн Соёлын Өвийн Хөтөлбөр, Монголын Сүм хийдийн түүхэн товчоон

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

2. Даржаалин
3. Шаддүвлин
4. Дашлин

Мөн

- 1.Цанид
- 2.Жүд
- 3.Дүйнхор
- 4.Зурхай
- 5.Манба
- 6.Майдар
- 7.Авид гэсэн 7 дацантай байсан.

1937, 38 оны үед 2500 гаруй ламтай байсан. Гавж миндагтай 360 хүн, Аграмбын миндагтай 150 хүн, хоёр их хувилгаан ламтай байсан. Миний багш Ноён лам Лувсанцэвээнравдан, Дарь Эхийн хувилгаан Агваанчүлтэмжамц лам юм. Одоогийн Шанхын хурал гэж байгаа тэнд Ноён лам өөрөө морилдог байсан. Ноён ламын сүм нэртэй. Дарь Эх хувилгаан нь Пунцагдаржаалин хийд нэртэй. Намайг бага байхад Шашин цөвтөхнээ гэр бүхэн гэлэнтэй, гэлэн бүхэн гэргийтэй, жалга бүхэн хуралтай боллоо гэж байсан. Манай тэнд Дайчингийн хурал, Төмрөнтийн хурал, Эрх цогтын хурал гээд өдий төдий хурал байсан. Хэн нэгэн Ноён би нэг хурал гаргана гээд албатуудаараа бариулчихдаг байсан байх. Үүнийг хуучуул их муушаадаг байсан. Одоо тэр өргөн хүрээгээр давтагдах гээд байна. Та нар залуу улсууд анхаар.

Би бар жилтэй хүн 1913 онд төрсөн Түшээт хаан аймгийн гол хошуу нутагт Далай гүний хошуу одоогийн Өвөрхангайн Бүрд сумд Шартын давааны ард Ойрдын хар толгой гэдэг газар төрсөн. 6 настай анх хүрээнд суусан. Чогчэнд хурсан миний багш Ноён лам, Дарь Эх хувилгаан. 8 настай Чогчэн, Магтаал төгсөөд 9 настай Барма равжүн санваар авч Баруун хүрээний Ламрим дацанд хурсан. 11 настай Жүд дацанд хурсан. 16 настай Дүйнхор дацанд хурсан. 20 настай гэлэн, гэцүл санваар авч Яр хайланд хурсан. Тэр үед аль ч газар лам нар 20 хүрээд гэлэн,гэцүл санваар авч Яр хайланд хурдаг байсан. Тэгээд 23, 24 настай засаг төрийн эрхээр хар болсон. Цэрэгт яваагүй манай багш нар намайг болж өгвөл цэрэгт бүү яваарай хүн алах буу зэвсэг битгий бариарай гэртээ хуучин номоо уншиж байгаарай гэж захисан татвар төлөөсийг нь өгөөд үлдсэн. Би хэсэгтээ хар болохгүй байж байгаад аав ээж, ах эгч нарын лам хэвээрээ байвал баригдаж тавигдах юм шиг байна гэж зөвлөсөнөөр хар болсон. Намын дээд сургуульд бичиг үсэгтэй 4 аргын тоо боддог хүнийг авна гэхээр нь Намын дээд сургуульд сурсан би хүрээнд байхдаа Монгол бичиг үсэг сурсан.

Өндөр гэгээн 13 настайдаа Шанх уулын өвөрт анхныхаа цогчныг долоон ламтай хурсан юм. Баруун хүрээний цогчэнгийн уншлага нь Өндөр гэгээний амны уншлагаар хурсан юм. Тэр хурж байсан дуган нь цээжин гэр байсан. Хана байхгүй. Сархинаг тооно гэж нугастай, шууд уньтайгаа залгагддаг. Хорло тооныг Өндөр гэгээн гаргасан. Өндөр гэгээний амны уншлага бол эхлээд Итгэл, Гурван гүрэм /Сэдэд, Дарь Эх, Шаравнимбо/,

Энэхүү нэр дурдсан хүний аман ярилцлагын үгчилсэн тэмдэглэл нь зөвхөн ярилцагчийн хувийн мэдээллээс бүрдсэн болно.

© Монголын Урлагийн Зөвлөлийн Соёлын Өвийн Хөтөлбөр, Монголын Сүм хийдийн түүхэн товчоон

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Жамбалцанжид, Ланжзавунамсан /Бурхан багшийн айлдсан Ламримийн анхны ном/ байсан юм. Тэгээд манайх бол Ламын чодва уншихгүй. Яагаад гэхлээр Ламын чодвыг Лувсанчойжанцан богд зохиосон юм. Манай зарим юм мэдэхгүй улсууд тэгдэг л байсан юм. Баруун хүрээ одоо Ламын чодов уншихгүй цогчэн хураад. Ямар цогчэн байдаг юм гэж.Тэгэхлээр тэр үед 1-рт Ламын чодов гараагүй байсан. 2-рт Өндөр гэгээний өдөр тутам уншдаг амны уншлагаар цогчэн хурлаа байгуулсан юм. Баруун хүрээний цогчэн уншлагын номнууд нь Дашчийрэв сан,ерөөл нь Санжидмоллом, Гурван гүрэм, Жамбалцанжид, Дарь Эх гэсэн горимтой байсан. Одоо ч гэсэн сэргээсэн хийд дээрээ энэ янзаараа хурдаг. Тэр анх цогчэн үүсгэсэн долоон ламын нэг нь дарагдаж үхсэн. Тэгсэн Өндөр гэгээн ирээдүйд миний шавь түм хүрэх нь гээд Батцагаан дуганыг барьсан гэж байгаа. Тэлүүртэй дуган байсан. Цогчэн дуганын дотор шар торгон бүтээлэгтэй алтан суврага байсан. Тэр нөгөө дарагдаж үхсэн ламын шарилыг суврагалаад дуган дотроо залсан нь тэр юм гэсэн. Тэгээд манай Баруун хүрээ явсаар байгаад 7 дацан, 4 аймаг, 2500-аад шавьтай, хоёр их хувилгаантай ийм их хүрээ болсон юм. Өндөр гэгээнээс хойш дараагийн богдууд дацангуудыг байгуулсан. Хамгийн түрүүнд Дүйнхор дацанг байгуулсан юм болов уу гэж би боддог. Халхын 4-р богд 13-р жарны үед Дүйнхорын дацанг байгуулсан.

Шамбалын орноо энэ биеэр очиж болно. “Ямар хүн очих вэ” гэсэн дээдсийн номлолд “Хувь төгөлдөр бясалгал хүчин төгс эзэмшсэн хүн олон саадыг даван чин зориг хатуужлаар очиж болно” гэсэн байдаг. Энэ талаар байдаг ном судруудаас жишээ татахад 1600 оны үед Халх монголын анхдугаар богд Жавзандамбад алс хол Жагарын орноос ид шидийн хүчээр залуу, хөгшин 2 азар ирж “Бид 2 энэ биеэр Шамбалд очих гэж явна, болох уу “ хэмээн асуухад Гэгээн бээр болох нь болно гээд замд тохиолдох сайн муу тохиолдлуудыг нэг бүрчлэн номлосноор тэр 2 азар явжээ. Гэгээний олон айлдвараас заримаас нь дурдвал:

1. Нэгэн ой шугуйн талбайд хэсэг тал бие, хар үстэй дүрстэй олон хүмүүс бүжиг наадам, цэнгэл хийж буй дайралдана. Тэд элдэв ааш араншин гаргана. Түүнийг арга эвийн эелдэг зөөлөн харьцвал гэм зэмгүй явуулна.
2. Мөн нэгэн их ой шугуйд олон мангасууд бий. Тэдгээрийн хөрөг дүрийг бүтээн тэр зүг харуулан чин сүжиг барьж явбаас цааш явж болно.
3. Цааш явахад алтан өнгөт уул бий. Тэр уулнаас Лянхуа хэмээх алтан цэцэг ургамлаас замын хоол хүнс, ундаа болгон 7 хоногт хүрэлцэхээр түүж аваад цааш явтал нэгэн их элсэн цөл их талыг 7 хоног туулахдаа нөгөө алтан өнгөт лянхуа цэцгээ идсэнээр бие махбодийн хүчин чадал улам нэмэгдэн зорьсон замаар цааш одоход саадгүй явна.
4. Цааш яваад Шамбалын орныг тойрон хүрээлсэн нэгэн их цаст уулын тойрон их хорт далай бий. Түүний захад очоод далайн тэнгэрийг урьж Дүйнхор бурханд залбирал тавин 7 хоног нямба бясалгал хийвэл уг далайгаас хөх өнгийн буга гарч ирнэ. Түүнийг барьж унаад хорт далайг гэтлэн Шамбалд очиж болно гэжээ.

Тэр 2 азар хүн дээр дурдсан үзэгдлүүдтэй таарч тулгаран даван туулсаар хорт далайн захад ирээд дээрхийн гэгээнтний айлдвараар 7 хоног нямба хийхийг зөвлөлдөхөд залуу азар бардам омог зан гаргаж:

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

“Бид 2 алс холоос ид шидийн хүчээр явж ирсэн. Тэр Халхын дунд сууж буй Занабазар юу мэдэх билээ. Нямба хийхгүй” гэж омогшин нөгөө далайд ормогц арьс мах, яс нь мулзраад юу ч үгүй болжээ. Харин хөгшин азар далайн захад очин энэ далай яадаг юм бол гэж бодлогошрон долоовор хуруугаа усанд дүрсэнд хуруу нь чулуу болжээ. Энэ Халхын Өндөр Гэгээн чинь Бодьсад Жанчивсэмбэ бодьтон мөн байна гэж бишрэн залбирч, буцан ирж Өндөр Гэгээн Занабазарт шавь орж Зургаадай таягаар Гэгээнийг 120 наслаарай гэж ерөөл өргөсөн гэдэг.

Энэ таяг нь миний шавилан сууж байсан Эрээбуу Ганданшадивлан, одоогийн Өвөрхангай аймгийн Шанх уулын өвөр, Саран голын хөвөө, Сайхан бүлгийн дэнжид 4 аймаг, 7 дацан, 2500 шавь хувраг бүхий Гэгээний анхны Баруун хүрээнд дээр дурдсан чулуун хуруут азрын таяг Түйн Толины эш болгон урьд Бурхан Очирдарийн гэр өргөөнд байдаг байсан билээ. Үүнийг Батцагаан эхийн дуганд “Чонпрүлжона” 15 өдөр, ерөөлт Очирдарийг 4 дэн гол бүхийгээр хүндэтгэн барьж түй өргөдөг байсан. Алтадсан дог толь бүхий таяг одоо Гандантэгчинлэн хийдийн 2 давхар модон сүмд байгаа билээ.